

ХБНГУ-ЫН ЭНХ ТАЙВНЫГ САХИН ХАМГААЛАХ ЗАРЧИМ БА ХОЛБООНЫ ЗЭВСЭГТ ХҮЧИН

*Ц.Лхам**

Дэлхийн хоёрдугаар дайны дараа буюу 1949 онд ХБНГУ байгуулагдахад түүний гадаад бодлогын үндсэн чиг шугам бүхэлдээ өөрчлөгдөж, энх тайвныг сахин хамгаалах зарчим нь түүний гадаад бодлогын үндсэн зарчмын нэг болж, ХБНГУ-ын Үндсэн хуулинаа тунхаглагдсан билээ.

ХБНГУ-ын Үндсэн хуулийн удиртгалд, Германы ард түмэн “дэлхийн энх тайвны төлөө хүчин зүтгэх хүсэл эрмэлзлээр дүүрэн байж...”¹ хэмээсэн бол Үндсэн хуулийн 1-р зүйлийн 2-д, “халдашгүй, дархан хүний эрх нь дэлхийн энх тайван, шударга ёс, хүмүүсийн нийгэмлэгийн тулгуур үндэс болохыг Германы ард түмэн нотолж байна”² гэсэн байдаг. Үндсэн хуулийн 24-р зүйлийн 2-д, холбооны улс нь энх тайвныг сахин хамгаалахаар хамтын харилцан аюулгүй байдлын тогтолцоонд нэгдэн орж болох бөгөөд чингэхдээ энэ нь дэлхийн ард түмнүүдийн дунд болон Европт урт удаан энх тайванч дэг журмыг тогтоох явдалд дэмжлэг үзүүлж чадахуйц байгаа үед л тусгаар тогтнолоо хязгаарлахыг зөвшөөрнө”³ гэжээ. Үндсэн хуулийн 26-р зүйлийн 1-д, “ард түмнүүд энх тайвнаар зэрэгцэн амьдрахыг бусниулах, ялангуяа түрэмгий дайныг явуулахад чиглэсэн буюу ийм сэдэл бүхий аливаа үйлдлийг Үндсэн хуулинд харш”⁴ хэмээн заасан байна.

Үндсэн хуулийн эдгээр заалтаас үзэхэд ХБНГУ нь энх тайвны төлөө хүчин зүтгэх ерөнхий чиг баримжааг барих бөгөөд чингэхдээ

- дэлхийн энх тайвны тулгуур үндэс болох хүний эрхийг дээдлэн сахих,
- энх тайвныг сахин хамгаалахаар хамтын харилцан аюулгүй байдлын тогтолцоонд нэгдэн орох,
- түрэмгий дайн хийхгүй байх гэсэн арга замыг хэрэглэж болохыг Үндсэн хуулинаа тодорхой зааж өгчээ.

Гэхдээ ХБНГУ-ын гадаад бодлогын түүхээс харахад ХБНГУ нь энх тайвныг сахин хамгаалах зарчмыг гадаад бодлогодоо хэрэгжүүлэхдээ зөвхөн дээр дурдсан арга замуудаар хязгаарлагдаагүй нь ажиглагдаж байна. Тухайлбал, 1971 онд Холбооны Засгийн газар хямралтай газруудад дайны зэр зэвсгийг экспортлохгүй байх журмыг гаргасан⁵ нь энх тайвныг сахин хамгаалах зорилгоор хийгдсэн нэг алхам гэж ойлгогдож байна. Мөн 1979 оны НАТО-гийн давхар шийдвэртэй холбогдуулж, батлан хамгаалах зорилгоор Америкийн дунд тусгалын

* Ц.Лхам - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

пуужинг ХБНГУ-ын нутаг дэвсгэр дээр байрлуулах эсэх асуудал Германы олон нийт болон намуудын дунд маргаан дэгдээх үед Холбооны Үндсэн хуулийн цэцийн зүгээс, Америкийн дунд тусгалын пуужинг байрлуулах нь Үндсэн хуулийн энх тайвныг сахин хамгаалах заалтыг зөрчихгүй юм байна гэсэн шийдвэрийг гаргасан байдаг.⁶

Практик амьдрал дээр иймэрхүү байдлаар энх тайвныг сахин хамгаалах арга зам, хэрэгслийг чөлөөтэйгээр сонгож буй нь Германы Үндсэн хуулинаа тусгагдсан энх тайвныг сахин хамгаалах чиг баримжааг ХБНГУ хэрэгжүүлэхдээ гадаад бодлогын чухам ямар арга хэрэгслийг ямар байдлаар ашиглах талаар нарийн тодорхой заагдсан зүйл байдаггүйтэй холбоотой гэж нэг талаар хэлж болох ч нөгөө талаар ерөөсөө ийм тодорхой механизм бүрэлдэн тогтох үйл явц үргэлжилсээр л байна гэж хэлж болохуйц байна.

Тухайлбал, энэ тухай Германы эрдэмтэн Штефан Бийрлинг хэлэхдээ, энх тайвныг сахин хамгаалах гадаад бодлогын ямар арга хэрэгслийг ашиглах нь эцсийн эцэст Холбооны Засгийн газар уг асуудлыг хэрхэн үзэж, дүгнэж буйгаас хамааралтай гэсэн дүгнэлтийг хийсэн⁷ бол харин эрдэмтэн Карл Дөринг, “Улс төрийн байдал цаг үргэлж өөрчлөгдөх боломжтой бөгөөд байнга өөрчлөгдөж байдаг. Ямар үнээр энх тайванг тогтоож чадах вэ гэсэн асуултанд Үндсэн хууль хариулж чаддаггүйн нэгэн адил ямар арга хэмжээ авч энх тайван байдлыг илүүтэй хамгаалж чадахыг ч урьдчилан хэлэх боломжгүй хэвээр байна” хэмээн онцлон тэмдэглэсэн байна.⁸

Улс орны гадаад, дотоод нөхцөл байдал үргэлж өөрчлөгдөж буйтай холбоотойгоор Германы Үндсэн хуулинд заасан энх тайвныг сахин хамгаалах арга замууд дотроос ялангуяа нэгдэн орсон харилцан хамтын аюулгүй байдлын тогтолцооныхоо хүрээнд энх тайвныг сахин хамгаалахдаа ХБНГУ нь Холбооны Зэвсэгт хүчнийг хэрхэн оролцуулах тухай асуудал яаж хувьсан өөрчлөгдсөөр ирсэн тухай авч үзье.

ХБНГУ нь 1973 онд НҮБ-д гишүүнээр элсэн орсон явдал нь Холбооны Үндсэн хуулийн 24 дугаар зүйлийн дагуу энх тайвныг сахин хамгаалах зорилгоор хамтын аюулгүй байдлын тогтолцоонд нэгдэн орсон хэрэг гарцаагүй мөн байсан билээ. Нэгэнт гишүүнээр элсэн орсон тул НҮБ-ын хүрээнд явагдаж буй аливаа үйл ажиллагаанд оролцох, оролцохыг шаардах нь зүйн хэрэг байлаа. 1970-аад оны дунд үеэс АНУ болон олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс цэнхэр дуулгатнуудын энхийг сахиулах үйл ажиллагаанд ХБНГУ-ыг оролцохыг сануулах болсон бөгөөд үүний хариуд ХБНГУ нь өөрийн Зэвсэгт хүчнийг НҮБ-ын хүрээнд хийгдэж буй аливаа хүмүүнлэгийн үйл ажиллагаанд буюу жишээлбэл эм болон бусад хэрэгцээт техник хэрэгслийг хүргэж өгөх байдлаар идэвхтэй оролцуулдаг ч харин 1970,

80-аад оны үед цөөхөн тоотой явагдсан энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцуулахаас татгалзсан хариуг өгдөг байв. Энэ нь нэгдүгээрт, дэлхийн хоёрдугаар дайны сургамж болж Германы ард түмэнд милитаризмын эсрэг сэтгэхүй түгээмэл тархсан хэвээр байгаатай холбоотой байв. Тодруулбал Германы эрдэмтэн Вильффрид фон Бредо “Ардчилал ба Зэвсэгт хүчин” номондоо дурдсанчлан “Дахин хэзээ ч Германы цэрэг үзэгдэхгүй байг, дахин хэзээ ч германчууд дайтахгүй байг!”⁹ гэсэн сэтгэхүй германчуудын дунд оршсоор байсан гэжээ. Үүний нэг нотолгоо бол ХБНГУ НАТО-д элссэнтэй холбогдуулж, 1955 онд Холбооны Зэвсэгт хүчнийг дахин байгуулсан нь олон нийтийн ихээхэн эсэргүүцэлтэй тулгарч байсан явдал юм. Үүний нэгэн адилаар Холбооны Зэвсэгт хүчнийг энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцуулж, ард түмний дургүйцэл, эсэргүүцлийг төрүүлэхээс тухайн үеийн Холбооны Засгийн газрууд болгоомжилж байсан болов уу. Хоёрдугаарт, нэг талаас ХБНГУ-ын Үндсэн хуулийн 87а-гийн 2-д, хэрэв Үндсэн хуулиар илтэд зөвшөөрсөн тохиолдолд Зэвсэгт хүчнийг батлан хамгаалахаас бусад зорилгоор ашиглаж болно¹⁰ гэсэн заалт, нөгөө талаас Үндсэн хуулийн 24-ийн 2-д, энх тайвныг сахин хамгаалах зорилгоор хамтын аюулгүй байдлын тогтолцоонд нэгдэж болох тухай заалт бий ч үүнийг шууд өргөжүүлэн ойлгох боломжгүй, цэргээ энхийг сахиулах хүчнээр оруулж болох тухай тодорхой заалт үгүй тул энэ нь Үндсэн хуулинд харш гэж улс төрийн бүх намууд тухайн үед санал нэгтэй үзэж байсан.¹¹ Гуравдугаарт, Цэнхэр дуулгатнуудын энхийг сахиулах үйл ажиллагаа 1970, 80-аад оны үед харьцангуй цөөн тоотой явагдсан тул ХБНГУ-д бусад гишүүн улсуудын зүгээс үзүүлэх шахалт дарамт тун бага байсан.

Харин 1987 оны зун Иран-Иракийн дайн дээд цэгтээ тулах үеэр АНУ Персийн буланг мингүйжүүлж, нефть тээвэрлэгч хөлөг онгоцнуудыг хамгаалахад зориулж, ХБНГУ-ыг тэсрэх бөмбөг илрүүлэгч онгоцнуудыг илгээхийг хүссэн боловч Холбооны Засгийн газар Үндсэн хуулинд нийцэхгүй гэсэн үндэслэлээр татгалзсан хариу өгч, харин хэдэн цөөхөн онгоцыг НАТО-гийн нутаг дэвсгэрт багтах Газрын дундад тэнгис хүртэл илгээсэн байдаг.¹²

1990 оны Персийн булангийн дайны үед НҮБ-ын цэргийг Иракт оруулахад ХБНГУ зэвсэгт хүчнээсээ илгээх, агаарын болон далайн тээврийн хүчин чадлаасаа ашиглуулах, АВС зэвсгээс хамгаалах багаж зэвсгээ хэрэглүүлэх, Туркт санхүүгийн тусламж үзүүлэх тухай асуудлыг Америкийн Батлан хамгааллын сайд Чени тавихад Холбооны Засгийн газар мөн л Үндсэн хуулийн заалтын улмаас Холбооны Зэвсэгт хүчнээс илгээхийг татгалзаж, харин энэхүү Саддам Хусейны эсрэг дайнд дипломат зөвшилцлөө илэрхийлж, өөрийн жилийн батлан хамгаалах

төсвийн 1/3-тэй тэнцэх хэмжээний мөнгөн дүн буюу 17 тэрбум ДМ-ийг гаргаж өгсөн билээ.¹³

Ингээд 1990 оны 12 дугаар сард болсон Бундестагийн сонгуулийн дараа үеэс Христосын Ардчилсан Холбоо /Христосын Нийгмийн Холбоо намын эвслийн зүгээс Холбооны Зэвсэгт хүчнийг энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцуулах нөхцлийг хангахын тулд Үндсэн хуулинд өөрчлөлт оруулах асуудлыг анх хөндөж эхэлсэн бөгөөд энэ үеэс уг асуудал Германы дотоодод нухацтай хэлэлцүүлэгдэх болсон. Германчуудын милитаризмын эсрэг сэтгэхүй бага багаар өөрчлөгдөж байгаа нь санал асуулгын дүнгээс харагдаж байлаа. 1990 онд Алленсбахын Институтын санал асуулгад оролцогч баруун германчуудын 24%, зүүн германчуудын 19% нь Холбооны Зэвсэгт хүчний цэргүүдийг НҮБ-ын энхийн үйл ажиллагаанд оролцохыг зөвшөөрсөн бол 1992 оны санал асуулгын дүнд энэ тоо 45%, 26% болж тус тус өссөнийг¹⁴ зарим эрдэмтэд тайлбарлахдаа, ХБНГУ-д дэлхийн 2 дугаар дайныг нүдээрээ үзэж биеэрээ туулсан нэгэн үе шинэ залуу үеийнхээр солигдож буйтай холбон үздэг бололтой. Мөн үүнээс гадна социалист систем задран унасан, дэлхий дахинд зэвсэгт мөргөлдөөн, тэмцэл огцом нэмэгдсэн, Өрнө-Дорнын сэргөлдөөн үгүй болж, хоёр Герман нэгдсэнээр түүний дэлхийд эзлэх байр суурь, хүлээх үүрэг хариуцлага нэмэгдсэнтэй холбоотойгоор олон улсын хамтын нийгэмлэг, холбоотон гүрнүүдийн зүгээс дэлхий дахины энх тайвны үйл хэрэгт ХБНГУ-ыг илүү идэвхтэй оролцохыг шаардан шахах болсон явдлын нөлөөн дор 1992 оны зун Холбооны Засгийн газар НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлөөс Югослав, Серб, Монтенегрогийн эсрэг тогтоосон хоригийг хянахад оролцох, Германы хөлөг онгоц, тэнгисийн нисэх онгоцыг НАТО, Баруун Европын Холбооны хамтарсан арга хэмжээний хүрээнд Адриа руу илгээх шийдвэрийг гаргасантай холбогдуулж, Бундестаг дахь Германы Социальдемократ Нам (ГСДН)-ын фракцын гишүүд Үндсэн хуулийн цэцэд гомдол мэдүүлсэн байна. Мөн НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлөөс 1993 оны хавар Боснийн-Херцоговинад нисэхийг хориглосон шийдвэрийг гаргаж, хяналт тавих үүргийг НАТО-д шилжүүлсний дараа агаарын хяналтын систем бүхий (AWACS) онгоцнуудын тусламжтайгаар гол үүргийг гүйцэтгэх ёстой НАТО-гийн бие бүрэлдэхүүнд германы цэргүүд оролцох ёстой болсон бөгөөд үүнд германы цэргүүдийг оролцуулах тухай шийдвэр нь Үндсэн хуулинд нийцэж буй эсэхийг шалгуулахаар Бундестаг дахь Германы Чөлөөт Ардчилсан Нам (ГЧАН)-ын фракц Үндсэн хуулийн Цэцэд хандсан бөгөөд үүнд мөн ГСДН-ын фракц ч нэгдсэн байна. AWACS-ын онгоцтой цуг Германы цэргүүдийг оролцуулахыг эсэргүүцсэн хамтарсан гомдлыг няцаасан шийдвэрийг Үндсэн хуулийн цэц 1993 оны 4 дүгээр сарын 8-

нд 5:3 саналаар гаргасан байна. 1992 оны хавар Сомалийн улс төрийн самуунтай байдлыг намжааж, хүмүүнлэгийн яаралтай тусламж үзүүлэх тухай НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн удаа дараагийн шийдвэрүүдийн үндсэн дээр Холбооны Зэвсэгт хүчин уг бүс нутагт хэрэгжүүлэх хүмүүнлэгийн үйл ажиллагаанд оролцох шийдвэрийг Холбооны Засгийн газар 1993 оны 4 дүгээр сарын 21-нд гаргаж, мөн уг өдөр уг шийдвэрийг Бундестаг хүлээн зөвшөөрсөн байна. Гэвч төдөлгүй Сомалид иргэний дайны намууд болон НҮБ-ын цэргийн хооронд зэвсэгт мөргөлдөөн гарах үед Бундестагийн ГСДН-ын фракцийн зүгээс Засгийн газрынхаа шийдвэрийг цуцлуулахаар Холбооны Үндсэн хуулийн цэцэд хандсан байна. Германчуудын оролцоог үргэлжлүүлэх эсэх нь Бундестагийн бие даасан шийдвэрээс хамаарна гэсэн шийдийг Үндсэн хуулийн цэц 1993 оны 6 дугаар сарын 23-нд гаргасан байна.¹⁵

Эл асуудлыг нэг мөр болгож, Холбооны Үндсэн Хуулийн цэц 1994 оны 7 дугаар сард шийдвэрээ гаргасан бөгөөд үүнд “Үндсэн Хуулийн 24 дүгээр зүйлийн 2 нь харилцан хамтын аюулгүй байдлын тогтолцоонд нэгдэн орж, улмаар тусгаар тогтнох эрхээ хязгаарлах явдлыг хүлээн зөвшөөрөх эрхийг холбооны улсад олгодог төдийгүй ийнхүү хамтын аюулгүй байдлын тогтолцоонд нэгдэн орсноор үүрэг хүлээж улмаар энэ тогтолцооны хүрээнд, дүрэм журмынх нь дагуу Холбооны Зэвсэгт хүчнийг дайчлан ашиглах үндсэн хуулийн эрх зүйн үндэслэлийг бүрдүүлж байна” гэжээ. Цааш нь Үндсэн хуулийн 87а зүйл нь харилцан хамтын аюулгүй байдлын тогтолцооны хүрээнд Холбооны Зэвсэгт хүчнийг ашиглах үндсэн хуулийн эрх зүйн үндэслэл болж буй Үндсэн хуулийн 24-ийн 2-той харшилдахгүй юм. Эл зорилгоор Зэвсэгт хүчнийг ашиглах тухай бүрдээ Бундестагийн харьцангуй олонхийн саналаар зөвшөөрөл авах үүргийг Холбооны Засгийн газарт ногдуулсан байна.¹⁶ Холбооны Зэвсэгт хүчнийг энх тайвныг сахин хамгаалах зорилгоор гадаадад цэргийн ажиллагаанд оролцуулах асуудал ийнхүү шийдэгдсэний хойно харахад энэ асуудал нь үнэхээр үндсэн хуулийн эрх зүйн асуудлаас илүүтэйгээр улс төрийн шийдвэрийн асуудал байсан гэж Германы олон эрдэмтэд дүгнэсэнтэй санал нэгдэхүйц байна.

Эдгээр өөрчлөлтийн үр дүнд ХБНГУ нь 1992 оноос өнөөг хүртэл НҮБ, НАТО, ЕХ-ны мандаттайгаар гурван тив дамнуулан тухайлбал Камбожи, Руанда, Сомали, Босни-Херцеговина, Гүрж, Косово, Македони, Афганистанд олон арван энхийг сахиулах, энхийг тогтоох үйл ажиллагаанд Холбооны Зэвсэгт хүчний 7100 орчим бие бүрэлдэхүүнийг оролцуулаад байгаа¹⁷ билээ. Холбооны Зэвсэгт хүчнийг энх тайвныг сахин хамгаалах зорилгоор гадаадад цэргийн ажиллагаанд оролцуулах асуудал нь ХБНГУ Үндсэн хуулинаа тунхагласан зарчим, хэм хэмжээг биелүүлэх асуудлаар зөвхөн

хязгаарлагдахгүй бөгөөд эцсийн эцэст ХБНГУ-ын олон улсын хамтын нийгэмлэгт эзлэх байр сууриа нэмэгдүүлж, дэлхийн бодлогод идэвхтэй тоглогч байх асуудалтай эрхгүй холбогдох тул цаашид ч энэ хандлага тогтвортой үргэлжлэх төлөвтэй хэмээн үзэж, Монгол-Германы батлан хамгаалахын хамтын ажиллагааг олон улсын энхийг сахиулах ажиллагаанд оролцогч цэргийн бэлтгэлийг хамтран хангах, туршлага солилцох талыг анхааралдаа авах нь хоёр талын харилцааг харилцан ашигтай болгоход дусал нэмэр болох болов уу.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. „In Bewußtsein seiner Verantwortung vor Gott und den Menschen, von dem Willen beseelt, als gleichberechtigtes Glied in einem vereinten Europa, dem Frieden der Welt zu dienen, hat sich das deutsche Volk kraft seiner verfassungsgebenden Gewalt dieses Grundgesetz gegeben.“ Grundgesetz für die Bundesrepublik Deutschland, Prdambel, S. 1.
2. „Das Deutsche Volk bekennt sich darum zu unverletzlichen und unveräußerlichen Menschenrechten als Grundlage jeder menschlichen Gemeinschaft, des Friedens und der Gerechtigkeit in der Welt.“ Grundgesetz für die Bundesrepublik Deutschland, Artikel 1, S.2.
3. „Der Bund kann sich zur Wahrung des Friedens einem System gegenseitiger kollektiver Sicherheit einordnen; er wird hierbei in die Beschränkungen seiner Hoheitsrechte einwilligen, die eine friedliche und dauerhafte Ordnung in Europa und zwischen den Völkern der Welt herbeiführen und sichern.“ Grundgesetz für die Bundesrepublik Deutschland, Art.24, S.10.
4. „Die Handlungen, die geeignet sind und in der Absicht vorgenommen werden, das friedliche Zusammenleben der Völker zu stören, insbesondere die Führung eines Angriffskrieges vorzubereiten, sind verfassungswidrig.“ Grundgesetz für die Bundesrepublik Deutschland, Art.26, S.11.
5. Stephan Bierling, Die Außenpolitik der Bundesrepublik Deutschland, München, 1999, S.15.
6. BverfGE 66, 39(64/5)
7. Stephan Bierling, Die Außenpolitik der BRD, München, 1999, S.17.
8. Karl Doering: Das Friedensgebot des Grundgesetzes, in: Isensee/Kirchhof, 1992, S.708.

9. „Nie wieder deutsche Soldaten, nie wieder Krieg mit Deutschen und von Deutschland aus!“, Wilfried von Bredow, Demokratie und Streitkräfte, Wiesbaden 2000, S.13.
10. „Die Streitkräfte auÑer zur Verteidigung nur eingesetzt werden dürfen, soweit das Grundgesetz es ausdrücklich zulässt“, Grundgesetz für die Bundesrepublik Deutschland, Art.87a, Abs.2, S.18.
11. Gunther Hellmann, Deutsche Außenpolitik, Wiesbaden 2006, S.195.
12. Gunther Hellmann, Deutsche Außenpolitik, Wiesbaden 2006, S.196.
13. Christian Hacke, Die Außenpolitik der Bundesrepublik Deutschland, Ulm 2003, S.393-394.
14. Gunther Hellmann, Deutsche Außenpolitik, Wiesbaden 2006, S.198-199.
15. Stephan Bierling, Die Außenpolitik der Bundesrepublik Deutschland, München, 1999, S.17.
16. Vgl, Wilfried von Bredow, Demokratie und Streitkräfte, S.103; Entscheidungen des Bundesverfassungsgerichts, Bd. 90, Tübingen, 1994, S.286.
17. <http://www.bundeswehr.de/portal/a/bwde/kcxml/>